



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2023/253-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитын гүйцэтгэсэн: ЦЭСБ-АудитХХК Утас: 95112689 Цахим хаяг: <a href="mailto:tsesb.audit@gmail.com">tsesb.audit@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Setenge@audit.gov.mn

2023.02.25 № СЭА-2023/253-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 1,365,520.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 90.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 9.3 хувиар хэмнэсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар өгөгдсөн чиглэлийн дагуу цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал нэг удаагийн тэтгэмж урамшууллын

зардлаас нийт 126,472.2 мянган төгрөгийг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 54.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 26.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 6.7 хувийг нормативд зардал тус тус эзэлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>73,721,175.03</b>	<b>105,093,781.58</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>10,962.00</b>	<b>2.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа</b>	10,962.00	2.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>13,988,314.44</b>	-
<b>335</b>	Бусад авлага	13,906,800.00	-
	Хувь хүнээс авах	81,514.44	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>59,721,898.59</b>	<b>105,093,779.58</b>
<b>351</b>	Түүхий эд материал	-	<b>847,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал		847,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>56,826,898.59</b>	<b>96,001,779.58</b>
35410	Бичиг хэргийн материал		4,935,880.00
35420	Аж ахуйн материал	36,648,760.00	37,270,560.00
35430	Сэлбэг хэрэгсэл	705,958.00	705,958.00
35440	Түлш шатах тослох материал	492,000.00	258,250.00
35450	Барилгын засварын материал	8,748,310.00	10,702,810.00
35460	Хүнсний материал	2,312,634.30	6,479,585.29
35470	Бусад хангамжийн материал	7,919,236.29	35,648,736.29
<b>355</b>	<b>Биологийн хөрөнгө</b>	-	<b>5,000,000.00</b>
<b>356</b>	<b>Мал амьтад</b>	<b>2,895,000.00</b>	<b>3,245,000.00</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,270,148,803.73</b>	<b>3,069,409,887.70</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,270,148,803.73</b>	<b>3,069,409,887.70</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>3,102,570,803.73</b>	<b>2,892,833,554.37</b>
39201	Барилга байгууламж	3,624,133,570.00	3,624,133,570.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(587,442,882.39)	(778,115,571.03)
39217	Тээврийн хэрэгсэл	287,714,051.20	287,714,051.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(267,834,631.52)	(274,103,951.60)
39205	Машин тоног төхөөрөмж	220,353,999.80	223,083,799.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(191,694,561.28)	(204,849,910.96)
39207	Тавилга, эд хогшил	34,958,720.00	34,958,720.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,485,596.08)	(28,955,287.04)
39217	Ном	8,868,134.00	8,968,134.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>167,578,000.00</b>	<b>176,576,333.33</b>
39301	Программ хангамж	16,805,000.00	25,960,000.00
39302	Хасагдуулга	(16,805,000.00)	(16,961,666.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	167,578,000.00	167,578,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,343,869,978.76</b>	<b>3,174,503,669.28</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,343,869,978.76</b>	<b>3,174,503,669.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,343,869,978.76</b>	<b>3,174,503,669.28</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	1,111,180,818.68	1,111,180,818.68
51101	Өмч: -төрийн	1,111,180,818.68	1,111,180,818.68
512	Хуримтлагдсан үр дүн	(1,879,617,721.32)	(2,048,984,030.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,879,617,721.32)	(1,879,617,721.32)
51220	Тайлант үеийн үр дүн		(169,366,309.48)
51300	Дахин үнэлгээний зөрүү	4,112,306,881.40	4,112,306,881.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,343,869,978.76</b>	<b>3,174,503,669.28</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,189,912,205.80</b>	<b>1,391,441,906.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,621,483.80</b>	<b>25,920,956.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>18,621,483.80</b>	<b>25,920,956.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,621,483.80	19,475,956.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,016,200.00	19,475,956.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,705,283.80	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	300,000.00	6,410,000.00
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,171,290,722.00</b>	<b>1,365,520,950.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,164,629,900.00</b>	<b>969,240,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,164,629,900.00	969,240,200.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,660,822.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	6,660,822.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>396,315,750.0</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		396,315,750.0
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>1,356,523,954.99</b>	<b>1,560,778,215.48</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>1,356,523,954.99</b>	<b>1,560,778,215.48</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1,262,871,083.99</b>	<b>1,383,684,665.81</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>593,968,660.99</b>	<b>596,839,667.09</b>
210101	Үндсэн цалин	353,352,772.34	373,568,418.97
210102	Нэмэгдэл цалин	177,476,499.83	165,376,202.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,343,583.02	26,942,842.84
210104	Урамшуулал	32,795,805.80	30,952,202.97
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>73,510,594.03</b>	<b>76,769,627.88</b>
210201	Тэтгэврийн даатгалын	50,334,208.92	53,081,624.84
210202	тэтгэмжийн даатгалын	5,917,689.79	6,152,265.48
210203	ҮОМШӨ-ий даатгалын	5,928,312.43	4,837,772.41
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,013,985.01	1,130,556.27
210205	ЭМ-ийн даатгалын	10,316,397.88	11,567,408.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>330,239,659.54</b>	<b>346,017,798.80</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	18,476,459.54	22,463,898.80
210302	Түлш, халаалтын зардал	309,063,200.00	322,970,000.00
210303	Цэвэр бохир усны зардал	2,700,000.00	583,900.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,187,590.00</b>	<b>30,197,280.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	2,029,000.00	3,967,120.00
210404	Тээвэр шатахуун	5,468,000.00	10,641,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	2,690,740.00	2,421,320.00
210404	Ном, хэвлэл	33,300.00	540,000.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,697,800.00	960,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	7,058,750.00	10,637,840.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	210,000.00	1,030,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>14,114,773.70</b>	<b>72,100,335.01</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	984,200.00	381,800.00
210502	Хоол, хүнс	12,288,373.70	71,718,535.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	842,200.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,340,100.00</b>	<b>28,439,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	8,600.00	4317143998
210604	Урсгал засварын зардал	5,331,500.00	28,439,000.00
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>	<b>-</b>	<b>3,783,700.00</b>
210702	Дотоодын томилолт		3,783,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>3,978,772.00</b>	<b>4,298,041.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	950,000.00	1,800,000.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	1,440,000.00	1,480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	520,800.00	437,625.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,838.00	192,204.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264,000.00	264,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	488,922.00	100,000.00
210807	Газрын төлбөр	24,212.00	24,212.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>222,530,933.73</b>	<b>225,239,216.03</b>
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	11,283,300.00	12,515,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,247,633.73	212,723,716.03
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>93,652,871.00</b>	<b>177,093,549.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>88,648,800.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,656,200.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>50,551,860.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,712,000.00	48,399,860.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,280,600.00	2,152,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,004,071.00</b>	<b>125,477,558.24</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,004,071.00	125,477,558.24
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		34,456.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>1,064,131.43</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,064,131.43
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(166,611,749.19)</b>	<b>(169,336,309.48)</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		<b>30,000.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>30,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал- Бараа материал		30,000.00
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	<b>-</b>	<b>(30,000.00)</b>
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(166,611,749.19)</b>	<b>(169,366,309.48)</b>





210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		1,154,700.00
210604	Урсгал засвар	23,282,200.00	32,322,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>3,783,700.00</b>
210702	Дотоодын томилолт		3,783,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,969,850.00</b>	<b>11,873,541.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	950,000.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	520,800.00	437,625.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,838.00	220,204.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264,000.00	264,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	480,000.00	7,647,500.00
210807	Газрын төлбөр	24,212.00	24,212.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,474,300.00</b>	<b>22,254,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	11,474,300.00	22,254,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,652,871.00</b>	<b>177,093,549.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>88,648,800.00</b>	<b>50,551,860.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,656,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	34,712,000.00	48,399,860.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,280,600.00	2,152,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>125,477,558.24</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		125,443,102.24
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		34,456.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>1,064,131.43</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,064,131.43
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт</b>	<b>5,004,071.00</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,004,071.00	-
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>760,962.00</b>	<b>(10,960.00)</b>
<b>4</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>		
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	-	-
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	-	-
<b>7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>760,962.00</b>	<b>(10,960.00)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан



Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
<b>2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>943,602,818.68</b>	<b>4,112,306,881.40</b>	-	<b>5,055,909,700.08</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	943,602,818.68	4,112,306,881.40	-	5,055,909,700.08
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн	167,578,000.00		(1,879,617,721.32)	<b>(1,712,039,721.32)</b>
<b>2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,111,180,818.68</b>	<b>4,112,306,881.40</b>	<b>(1,879,617,721.32)</b>	<b>3,343,869,978.76</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт			-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(169,366,309.48)	<b>(169,366,309.48)</b>
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,111,180,818.68</b>	<b>4,112,306,881.40</b>	<b>(2,048,984,030.80)</b>	<b>3,174,503,669.28</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,365,520,950.00	1,239,048,716.33	126,472,233.67	90.7
21	Урсгал зардлын дүн	1,365,520,950.00	1,239,048,716.33	126,472,233.67	90.7
210	Бараа үйлчилгээний зардал	1,315,968,450.00	1,189,496,856.33	126,471,593.67	90.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	703,772,200.00	596,839,667.09	106,932,532.91	84.8
210101	Үндсэн цалин	489,752,100.00	373,536,230.97	116,215,869.03	76.3
210102	Нэмэгдэл	156,180,800.00	165,408,390.31	(9,227,590.31)	105.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,903,900.00	26,934,042.84	2,969,857.16	90.1
210104	Урамшуулал	27,935,400.00	30,961,002.97	(3,025,602.97)	110.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,897,400.00	76,688,113.44	14,209,286.56	84.4
210201	Тэтгэврийн даатгал	65,686,100.00	53,000,110.40	12,685,989.60	80.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,302,800.00	6,152,265.48	150,534.52	97.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,042,200.00	4,837,772.41	204,427.59	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,260,600.00	1,130,556.27	130,043.73	89.7
210205	ЭМД-ын хураамж	12,605,700.00	11,567,408.88	1,038,291.12	91.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,174,150.00	332,110,998.80	1,063,151.20	99.7
210301	Гэрэл цахилгааны зардал	24,992,000.00	22,463,898.80	2,528,101.20	89.9
210302	Түлш, халаалтын зардал	307,582,150.00	309,063,200.00	(1,481,050.00)	100.5
210303	Цэвэр бохир усны зардал	600,000.00	583,900.00	16,100.00	97.3
2104	Хангамж, бараа материалын зардал	26,873,400.00	26,860,150.00	13,250.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,019,100.00	4,077,000.00	(2,057,900.00)	201.9
210402	Тээвэр шатахуун	4,730,900.00	10,407,250.00	(5,676,350.00)	220.0
210403	Шуудан холбоо	4,241,200.00	2,421,320.00	1,819,880.00	57.1
210404	Ном	665,900.00	160,000.00	505,900.00	24.0
210405	Хог хаягдал	10,083,900.00	960,000.00	9,123,900.00	9.5
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	5,132,400.00	8,834,580.00	(3,702,180.00)	172.1
2105	Нормативт зардал	84,629,600.00	82,760,586.00	1,869,014.00	97.8
210501	Эм	391,800.00	391,800.00	-	100.0
210502	Хоол хүнс	77,700,000.00	75,885,486.00	1,814,514.00	97.7
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	6,537,800.00	6,483,300.00	54,500.00	99.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,141,500.00	39,327,200.00	814,300.00	98.0
210601	Багаж, техник хэрэгсэл	6,700,000.00	6,700,000.00		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,968,100.00	1,154,700.00	813,400.00	58.7
210604	Урсгал засвар	31,473,400.00	31,472,500.00	900.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,665,000.00	3,783,700.00	881,300.00	81.1
210702	Дотоод томилолт	4,665,000.00	3,783,700.00	881,300.00	81.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	10,762,300.00	10,073,541.00	688,759.00	93.6

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,480,000.00	20,000.00	98.7
210803	Даатгалын үйлчилгээ	468,700.00	437,625.00	31,075.00	93.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	333,000.00	220,204.00	112,796.00	66.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	280,900.00	264,000.00	16,900.00	94.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	8,015,000.00	7,647,500.00	367,500.00	95.4
210807	Газрын төлбөр	164,700.00	24,212.00	140,488.00	14.7
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,052,900.00</b>	<b>21,052,900.00</b>	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,052,900.00	21,052,900.00	-	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,552,500.00</b>	<b>49,551,860.00</b>	640.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,552,500.00	49,551,860.00	640.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	48,400,000.00	48,399,860.00	140.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,152,500.00	1,152,000.00	500.00	100.0
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,365,520,950.00</b>	<b>1,239,048,716.33</b>	<b>126,472,233.67</b>	90.7
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>969,205,200.00</b>	<b>843,797,097.76</b>	<b>125,408,102.24</b>	87.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	969,205,200.00	843,797,097.76	125,408,102.24	87.1
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>396,315,750.00</b>	<b>395,251,618.57</b>	<b>1,064,131.43</b>	99.7
132001	Орон нутгийн төсвөөс	396,315,750.00	395,251,618.57	1,064,131.43	99.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан


/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө</b>	<b>19,441,500.00</b>	<b>19,441,500.00</b>		100.0
II. Нийт зарлагын дүн	19,441,500.00	19,441,500.00		100.0
IV. Урсгал зардлын дүн	19,441,500.00	19,441,500.00		100.0
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>18,441,500.00</b>	<b>18,441,500.00</b>	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	4,269,500.00	4,269,500.00	-	100.0
Ном хэвлэл	480,000.00	480,000.00	-	
БҮТЭЗ	3,789,500.00	3,789,500.00	-	100.0
Нормативт зардал	10,320,000.00	10,320,000.00	-	100.0
Нормын хувцас зөөлөн эдлэл	10,320,000.00	10,320,000.00	-	100.0
Эд хогшил худалдан авах	850,000.00	850,000.00	-	100.0
Урсгал засвар	850,000.00	850,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамж	1,800,000.00	1,800,000.00		
Бараа үйлчилгээний бусад зардал	1,202,000.00	1,202,000.00	-	100.0
Хичээл үйлд-ийн дадлага хийх	1,202,000.00	1,202,000.00	-	
Татаас	-	-	-	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос		19,475,956.00		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь *Ицаашид МСҮТ гэх* “Багш, ажилтан, суралцагчдын мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлж тэдний ажиллах ая тухтай таатай орчинг бүрдүүлж ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.



Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах,
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,
- Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах гэх мэт.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Байгууллагын дотоод хяналтын албанаас ажлын төлөвлөгөө гарган хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, дотуур байрны үйл ажиллагаа, цалин хөлс, урамшууллын төсвийн зарцуулалт, өр

авлага түүний барагдуулалт, боловсролын бичиг баримтын бүрдүүлэлт, тэтгэлгийн ирцэд хяналт тавих зэрэг ажлуудыг хянаж шалгахаар төлөвлөгөө гарган батлуулж, хяналт үнэлгээг тухай бүрт хийж тайлагнах зэргээр дотоод хяналтыг хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас байгууллагын 2019, 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, эрхийн актуудыг 96,0-100.0 хувьтай хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийг зориулалтаар нь үр дүнтэй зарцуулж, тайлагнасан байна гэж дүгнэжээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын МСҮТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Шаамар сумын МСҮТ нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Шаамар сумын МСҮТ-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.



Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 169,366.2 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.



*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.9	0.02	(10.9)
Авлага	13,988.3	-	(13,988.3)
Бараа материал	59,721.9	105,093.8	45,371.9
Үндсэн хөрөнгө	3,270,148.8	3,069,409.9	(200,738.9)
Нийт хөрөнгө	<b>3,343,869.9</b>	<b>3,174,503.7</b>	<b>(169,366.2)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,343,869.9	3,174,503.7	<b>(169,366.2)</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,343,869.9</b>	<b>3,174,503.7</b>	<b>(169,366.2)</b>

Авлага данс оны эхэнд 13,988.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол өмнөх онд үүссэн халаалтын төлбөрийн авлагыг тайлант онд барагдуулснаас жилийн эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 105,093.8 мянган төгрөг болж 45,371.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 181,467.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон үйл ажиллагаанд 136,095.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,372,396.3 мянган төгрөг болж 11,984.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,729.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9,155.0 мянган төгрөгийн программ хангамж, 100.0 мянган төгрөгийн ном худалдан авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,174,503.6 мянган төгрөг болж 169,366.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.


### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,004,668.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 338,401.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,343,069.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 13,775.6 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 11,538.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 742.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,467.3 мянган төгрөгөөр тус тус өсгөн, байр ашиглалттай холбоотой зардлыг 5,510.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,177.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 385.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт төсвийг 1,365,520.9 мянган төгрөгөөр баталсан байна.



### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 969,205.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 396,315.7 мянган төгрөг, нийт 1,365,520.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,239,048.7 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 106,932.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 14,209.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,063.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 13.2 мянган төгрөг, нормативт зардал 1,869.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 814.3 мянган төгрөг, томилолтын зардал 881.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 688.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлын 0.6 мянган төгрөг, нийт 126,472.2 мянган төгрөгийг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71804 Мэргэжлийн боловсрол	1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	842,236.0	718,359.9	123,876.1	85.3
		2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	49,552.5	49,551.9	0.6	99.9
		3	81806- Дотуур байрны хүүхдийн хоол	77,700.0	75,885.4	1,814.6	89.9
		4	80111- Байр ашиглалтын үйлчилгээ	345,874.8	345,094.0	780.8	99.7
		5	80112- Нийтлэг үйлчилгээ	50,157.6	50,157.5	0.1	99.9
			<b>Нийт</b>	<b>1,365,520.9</b>	<b>1,239,048.7</b>	<b>126,472.2</b>	<b>90.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Юнител, Скайтел ХХК-ийн антен түрээсийн болон ажиллагсдын байрны түрээсийн орлогоос 19,475.9 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулан, үлдэгдэл 34.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын МСҮТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.


Мөн анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын МСҮТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.



Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,356,534.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,565.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шаамар сумын МСҮТ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Цалингийн зардлаас 106,932.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 14,209.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,063.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 13.2 мянган төгрөг, нормативт зардал 1,869.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 814.3 мянган төгрөг, томилолтын зардал 881.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 688.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлын 0.6 мянган төгрөг зэрэг нийт 126,472.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.


##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст тухай бүр мэдээлбэл зохих 13 удаа мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх гэх чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох

журам"-ын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.



Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

"ЦЭСБ-Аудит" ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 21-ний өдрийн 1/219 дугаар албан бичгээр "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон 896.2 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байх болон төлбөрийн цахим баримттай холбоотой 68,627.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснөөс бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулалгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	896.2	1	896.2	100.0
Зөвлөмж	1	68,627.2			-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>69,523.8</b>	<b>1</b>	<b>896.2</b>	<b>50.0</b>

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тус МСҮТ-ийн дотуур байрны хоолны нормативт зардал болон тээвэр шатахууны зарцуулалтыг тулган баталгаажуулаагүй тул дараагийн аудитаар анхан шатны баримтууд руу хөөн шалгах нь зүйтэй юм.



#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар дараах 2,265.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Аж ахуйн материалын дансанд 1,851.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал бүртгэсэн,
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 413.5 мянган төгрөгийн худгийн моторыг шууд зардлаар бүртгэж, тайлагнасан,

Аудитаар нийт **17,996.0** мянган төгрөгийн зөрчил илэрч 3,825.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8,157.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 6,013.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

##### 5.1 Төлбөрийн акт


1. Хичээл сургалтын үйл ажиллагаанд бус аж ахуйн ажлыг илүү цагаар ажиллаж гүйцэтгэсэн гэх үндэслэлээр захирал, захиргаа аж ахуйн менежер, захирлын туслах, бичиг хэрэг, архивын ажилтан зэрэг 14 албан хаагчид тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн **3,825.4** мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3 дахь” Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд **тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй** байна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

##### 5.2 Албан шаардлага

1. Батлагдсан цалингийн зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,042.8 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлэх албан шаардлага хүргүүлэх.



2. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **4,114.8** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**


Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангахгүйгээр 6,013.0 мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ӨХБЗ-ийн болон техникийн комиссын актгүйгээр машины засварт 1,082.0 мянган төгрөг,
- Засварын ажлын төсөв, хийсэн ажлын тайлангүйгээр урсгал засварт 2,333.0 мянган төгрөг,
- Худалдах, худалдан авах гэрээ, нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэхгүйгээр тоног төхөөрөмж худалдан авахад BSB электроникс компанид 2,598.0 мянган төгрөг гэх мэт.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

#### **2. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.” 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга.” гэсэн заалтыг зөрчсөн байна.



Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу тайлант оны санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг иж бүрэн хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ


#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дансны ангилал буруу бүртгэсэн	1	1,851.9			1	1,851.9	1	1,851.9				
Хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн	1	413.5			1	413.5	1	413.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,265.4</b>			<b>2</b>	<b>2,265.4</b>	<b>2</b>	<b>2,265.4</b>				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс					
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Илүү цагийн хөлсийг илүү олгосон	1	3,825.4	1	3,825.4								
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	4,042.8			1	4,042.8						
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	4,114.8			1	4,114.8						
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	3	6,013.0					3	6,013.0				
Тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1						1					
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>17,996.0</b>	<b>1</b>	<b>3,825.4</b>	<b>2</b>	<b>8,157.6</b>	<b>4</b>	<b>6,013.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	13				13			
Дүн	<b>13</b>				<b>13</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>13</b>				<b>13</b>			